



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 112

Бөхт

┌ Үндсэн хөрөнгө бүртгэлд авах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.11, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн 14.4.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын төсвийн байгууллагуудад 2023 онд улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламжаар орж ирсэн 17 нэр төрлийн 18,988,000.00 (Арван найман сая есөн зуун наян найман мянган) төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэхийг зөвшөөрч хавсралтаар баталсугай.

2.Хөрөнгийг холбогдох журамд заасны дагуу бүртгэлд тусгахыг Сумын Засаг дарга (У.Алтанхүү)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.МӨНХЦЭЦЭГ

482301063

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны
09 дүгээр сарын 20-ны 112 дугаар тогтоолын хавсралт

ШИНЭЭР БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Эх үүсвэр
1. Иргэдийн төлөөлөгчдийн хурал					
1	Канон өнгөт принтер	1	680,000	680,000	ОНТөсөв
2	Алкотест 6820	1	3,320,000	3,320,000	ОНТөсөв
НИЙТ ДҮН		1		4,000,000	
2. Ерөнхий боловсролын сургууль					
1	Ширээ	97	22,000	2,134,000	Хандив
2	Сандал	102	12,000	1,224,000	Хандив
3	Төмөр шкаф	10	120,000	1,200,000	Хандив
4	Проектор	3	500,000	1,500,000	Хандив
5	Самбар	10	70,000	700,000	Хандив
6	Сандал шүүгээтэй	6	35,000	210,000	Хандив
НИЙТ ДҮН				6,968,000	
3. Хүүхдийн цэцэрлэг					
1	Хүүхдийн ор	37	30,000	1,110,000	Хандив
2	Хүүхдийн сандал	30	15,000	450,000	Хандив
3	Хүүхдийн ширээ	5	80,000	400,000	Хандив
4	Номын тавиур	1	60,000	60,000	Хандив
5	Тоглоомын тавиур	1	100,000	100,000	Хандив
6	Модон шкаф	1	50,000	50,000	Хандив
7	Принтерийн модон тавиур	1	50,000	50,000	Хандив
НИЙТ ДҮН		7		2,220,000	
4. Эрүүл мэндийн төв					
	Хог ангилан ялгах сав	1	5,500,000	5,500,000	УТөсөв
	Кварцын апарат	1	300,000	300,000	Хандив
				5,800,000	